



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ЦЕМЕНТ ШОХОЙ ТӨХК-ИЙН 2022 ОНЫ НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН  
ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: СНАГ-2023/08/НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу.



Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх  
аудитор : Ц.Наранчимэг  
Утас: 51-261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn  
Аудитын менежер: Я.Самбууням  
Утас: 51-260949 Цахим хаяг: sambuunyamyaya@audit.gov.mn  
Аудитор: Б.Лхагвацэнд  
Утас: 51-263533 Цахим хаяг: lkhagvatsendb@audit.gov.mn  
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Ди Эй Би Жи Аудит ХХК-ийн  
захирал Н.Дэлгэрмаа  
Утас: 976-91910954 Цахим хаяг: dabg.audit@yahoo.com

Улаанбаатар хот  
2023 он

**АГУУЛГА**

<b>1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ</b> .....	3
<b>2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН</b> .....	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	6
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан.....	8
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	9
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	10
<b>3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА</b> .....	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт.....	13
3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл.....	15
<b>4. АУДИТЫН ТАЙЛАН</b> .....	16
4.1 Ерөнхий зүйл.....	16
4.2 Материаллаг байдал.....	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	17
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	18
4.5.1 Завсрын аудитын талаар.....	18
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн.....	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	18
<b>5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ</b> .....	19
5.1 Төлбөрийн акт.....	19
5.2 Албан шаардлага.....	20
5.3 Зөвлөмж.....	22
<b>6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ</b> .....	24
6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл.....	24
6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл.....	25
6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	299

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗГХЭХ	Засгийн Газрын Хэрэг Эрхлэх Газар
ТБОНӨХБАУХАА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагаа
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ЭБЦТС	Эрдэнэт булганы цахилгаан түгээх станц



Аудитын нэр: Цемент шохой ТӨХК  
Аудитын код: СНАГ-2023/08/НА-СТА-ТӨА  
Тайлангийн хугацаа: 2022 он

2022 оны аудитын тайлан, албан шаардлага хүлээлгэн өгөх маягт

№	Утга	Огноо	Дугаар	Хуудсын тоо	Тэмдэглэл
1	Цемент шохой ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан	2022 он		24	Хэвлэмэл тайлан
2	Аудитын дүгнэлт	2023.03.24	№07/666	3	Эх хувь
3	Зөрчил арилгах тухай албан шаардлага	2023.03.24	№731/A0150116	1	Эх хувь
4	Зөрчил арилгах тухай албан шаардлага	2023.03.24	№730/A0150116	2	Эх хувь
5	Зөрчил арилгах тухай албан шаардлага	2023.03.24	№729/A0150116	1	Эх хувь
6	Зөрчил арилгах тухай албан шаардлага	2023.03.24	№728/A0150116	1	Эх хувь
7	Зөрчил арилгах тухай албан шаардлага	2023.03.24	№727/A0150116	2	Эх хувь
8	Зөрчил арилгах тухай албан шаардлага	2023.03.24	№726/A0150116	2	Эх хувь
9	Зөрчил арилгах тухай албан шаардлага	2023.03.24	№725/A0150116	2	Эх хувь
10	Зөрчил арилгах тухай албан шаардлага	2023.03.24	№724/A0150116	1	Эх хувь
11	Төлбөр барагдуулах тухай	2023.03.24	№185/A0150116	1	Эх хувь
12	Төлбөр барагдуулах тухай	2023.03.24	№184/A0150116	1	Эх хувь

Хүлээлгэн өгсөн: Ди Эй Би Жи Аудит ХХК-ийн аудитор

С.Цэнгэлмаа Огноо: 2023.04.05

Хүлээн авсан: Цемент шохой ТӨХК-ийн  
Гүйцэтгэх захиарл

Л.Наранбаатар Огноо: 2023.04.06

Санхүү, бүртгэл тайлангийн хэлтсийн дарга

Э.Гэлэгжамц Огноо: 2023.04.06





## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас: 26-04-37, Факс: 51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

ЦЕМЕНТ ШОХОЙ ТӨХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
Л.НАРАНБААТАР ТАНАА

2023.03.24 № 07/666  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -г

### Сөрөг дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Цемент шохой ТӨХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ. Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн мэдэгдэхүйц нөлөөний улмаас Цемент шохой ТӨХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулаагүй байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн дараах залруулагдаагүй алдаа, зөрчил нь тогтоосон 485.8 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс давсан тул дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг ба өргөн тархсан санхүүгийн тайлангийн толилуулга, үнэлгээ ба хуваарилалт, тасалбар болголт, оршин байх, үнэн зөв, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна. Үүнд:

- Компанийн 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланд төрд шилжин ирсэн үеийн хугацааны 70,072.4 сая төгрөгийн зарцуулалт тайлагнасан ч төлөвлөгөөний үзүүлэлтийг харгалзах хугацаагаар зэрэгцүүлээгүй, санхүүгийн тайлангийн тоо хэмжээ, өртөгтэй уялдуулаагүй, бодитой, ил тод тайлагнаагүй;
- Нээлттэй тендер шалгаруулсан 3 ажлын 908.8 сая, харьцуулалтын 3 ажлын 207.5 сая төгрөгийн гэрээнүүдийг аудитад ирүүлээгүй, 16 ажлын 5,890.3 сая төгрөгийн гэрээ дүгнэсэн актгүй, худалдан авалтын гэрээний хэрэгжилтэд нийт 7,006.6 сая төгрөгийн зөрчилтэй. Тайлант онд бэлтгэн нийлүүлэгчдэд дээрх гэрээнүүдийн төлбөрт 4,191.6 сая төгрөгийг зарцуулсан;
- Худалдан авалтын төлөвлөгөөнд батлуулаагүй, нээлттэй тендер шалгаруулах босго давсан 2,187.9 сая төгрөгийн 11 гэрээ, харьцуулалтын аргын босго 645.7 сая төгрөгийн 16 гэрээг шууд худалдан авалт хийсэн, гэрээг аудитад ирүүлээгүй;
- Борлуулах зорилготой эргэлтийн бус хөрөнгөнд бүртгэлтэй 546.2 сая төгрөгийн өртөгтэй ККС-110 маркийн байшин кран байгууллагын эзэмшилд биетээр оршин байхгүй;
- Хэрэгцээ, шаардлагыг тодорхойлохгүй худалдан авалт хийснээс 816.9 сая төгрөгийн илүүдэл бараа материалын нөөц үүсгэсэн зэрэг болно.

Z:\Yawsan\_Bichigi\2023\0315 SNAG-112.Docx

0001051261



## **Асуудлыг онцолсон хэсэг**

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны “Хөтөлийн цемент шохой ТӨХК-ийн хувьчлалын талаар авах арга хэмжээний тухай” 124 дүгээр тогтоол, ТӨБЗГ-ын 2022 оны “Хувьчлалыг хүчингүйд тооцох, компанийн эрх, эд хөрөнгийг хүлээн авах тухай” 108 дугаар тогтоолоор Цемент шохой ХК-ийн хувьчлалыг хүчингүйд тооцож төрийн өмчид хүлээн авах шийдвэр гарсан байна.

ТӨБЗГ-ын даргын 2022 оны А/25 дугаар тушаалаар Цемент шохой ТӨХК-ийн удирдлагын эрх, хөрөнгийг хүлээлцэх, бүртгэн авах, бичиг баримтад хяналт шалгалт хийх, үйлдвэрийн үйл ажиллагааг хэвийн түвшинд явуулах арга хэмжээг зохион байгуулах санал, дүгнэлт гаргах ажлын хэсгийг 12 хүний бүрэлдэхүүнтэй томилон, 2022 оны 3 дугаар сарын 24-ний өдрөөс 31-ний өдрийг хүртэлх хугацаанд компанийн байранд ажиллаж, төрийн өмчид шилжүүлэн авах тогтоол, шийдвэрүүдийг хэрэгжүүлсэн байна.

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

## **Аудитын гол асуудал**

Цемент шохой ТӨХК нь 2022 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх хугацааны нэгтгэсэн санхүүгийн тайланг Барилга, хот байгуулалтын яамны төсвийн ерөнхийлөн захирагчийн багцын Э-ТАЙЛАН цахим системд тайлагнасан байна.

Санхүүгийн тайлангийн эхний үлдэгдэлд шүүхийн шийдвэр гараагүй маргаантай урт хугацаат банкны зээлийн өглөг 41,916.8 сая, зээлийн хүүгийн өглөг 16,372.6 сая, хуучнаар Цемент шохой ХК-ийн удирдлага төрийн шийдвэрийг эс зөвшөөрч, хоёр тал хүлээлцээгүй урт хугацаат хөрөнгө оруулалтын өглөг 275,738.8 сая, нэмж төлөгдсөн капитал 420.0 сая, эздийн өмчийн бусад хэсэг 2,861.6 сая төгрөг бүртгэлтэй байна.

Тайлант онд Цемент шохой ТӨХК-ийн 2012-2021 онуудад үүссэн хохирлыг 12 төрлөөр ангилан 374,510.1 сая төгрөгийг Хөтөл ХХК-иас хариуцуулахаар шүүхэд нэхэмжилсэн байна.

## **Бусад асуудлын хэсэг**

Компанийн 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан, тайлбар тодруулгад нийт жилийн дүнгээр 100,292.6 сая төгрөгийн орлоготой, 88,837.5 сая төгрөгийн зардалтай, 11,455.1 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан гэж тайлагнажээ.

Аудитын явцад 2023 оны 3 дугаар сарын 01-ний өдрөөс санхүү, эдийн засгийн хэлтсийн ажилтнуудын албан мэйлүүдийг хаасан нь аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авахад аудитын цаг хугацааны болон цар хүрээний хязгаарлалт үүссэн.



**Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой. Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм. Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ



Цемент шохой ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн  
тайланд хийсэн аудитын тайлан

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 4-р сарын 01	2022 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	493,830,628.79	6,085,783,120.23
1.1.2	Дансны авлага	4,505,148,374.68	3,535,106,457.36
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	546,950,910.40	1,026,014,956.21
1.1.4	Бусад авлага	5,290,566,859.08	6,499,879,373.41
1.1.5	Бараа материал	21,308,363,258.18	19,600,068,038.24
1.1.6	Урьдчилж төлсөн зардал/ тооцоо	2,074,774,370.36	2,592,433,765.74
1.1.7	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн хөрөнгө	546,192,946.00	546,192,946.00
	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>34,765,827,347.49</b>	<b>39,885,478,657.19</b>
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	236,796,052,118.59	232,978,820,699.40
1.2.2	Биет бус хөрөнгө	5,411,980,646.90	5,300,559,267.43
1.2.3	Хойшлогдсон татварын хөрөнгө	1,188,630,967.25	-
	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>243,396,663,732.74</b>	<b>238,279,379,966.83</b>
	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>278,162,491,080.23</b>	<b>278,164,858,624.02</b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
<b>2.1.1</b>	<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
2.1.1.1	Дансны өглөг	6,656,874,356.52	3,036,526,048.37
2.1.1.2	Цалингийн өглөг	1,062,670,371.97	85,055,555.02
2.1.1.3	Татварын өр	17,651,513,728.23	12,703,334,561.45
2.1.1.4	НДШ-ийн өглөг	5,795,707,632.92	55,470,381.08
2.1.1.5	Хүүгийн өглөг	16,155,458,946.34	16,372,618,946.34
2.1.1.6	Урьдчилж орсон орлого	3,826,058,037.10	3,952,807,965.76
2.1.1.7	Нөөц /өр төлбөр/	42,060,595.00	16,437,867.72
2.1.1.8	Бусад богино хугацаат өр төлбөр	249,187,517.26	249,187,517.26
	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>51,439,531,185.34</b>	<b>36,471,438,843.00</b>
<b>2.1.2</b>	<b>Урт хугацаат өр төлбөр</b>		
2.1.2.1	Урт хугацаат зээл	37,755,734,819.60	41,916,835,529.58
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/	2,695,574,355.24	2,213,391,285.66
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	4,070,578,039.51	3,731,424,605.08
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	275,738,820,300.00	275,738,820,300.00
	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>320,260,707,514.35</b>	<b>323,600,471,720.32</b>
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>371,700,238,699.69</b>	<b>360,071,910,563.32</b>
<b>2.3</b>	<b>Эзэмшигчдийн өмч</b>		
2.3.1	Өмч: а) төрийн	11,945,269,000.00	11,945,269,000.00
2.3.2	Нэмж төлөгдсөн капитал	420,000,000.00	420,000,000.00
2.3.3	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	41,284,046,790.95	41,284,046,790.95
2.3.4	Эздийн өмчийн бусад хэсэг	2,861,655,327.46	2,861,655,327.46



Цемент шохой ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн  
тайланд хийсэн аудитын тайлан

2.3.5	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	(150,048,718,737.87)	(138,418,023,057.71)
2.3.6	Өмнөх үеийн үр дүн	-	(150,048,718,737.87)
2.3.7	Тайлант үеийн үр дүн	(150,048,718,737.87)	11,630,695,680.16
	<b>Эзэмшигчдийн өмчийн дүн</b>	<b>(93,537,747,619.46)</b>	<b>(81,907,051,939.30)</b>
<b>2.4</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>	<b>278,162,491,080.23</b>	<b>278,164,858,624.02</b>



Цемент шохой ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн  
тайланд хийсэн аудитын тайлан

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2022 оны 4-р сарын 01	2022 оны 12-р сарын 31
1	<b>Борлуулалтын орлого</b>		<b>82,474,620,120.77</b>
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг		62,463,207,256.81
3	<b>Нийт ашиг (алдагдал)</b>		<b>20,011,412,863.96</b>
4	Түрээсийн орлого		10,991,219.19
5	Бусад орлого		661,480,308.11
6	Борлуулалт, маркетингийн зардал		1,984,409,771.11
7	Ерөнхий ба удирдлагын зардал		2,607,147,442.67
8	Бусад зардал		1,486,082,915.64
9	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		10,826,235.52
10	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>		<b>14,617,070,497.36</b>
11	Орлогын татварын зардал		2,986,374,817.20
12	Хойшлогдсон татварын зардал		-
13	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>		<b>11,630,695,680.16</b>
14	<b>Тайлант үеийн цэвэр үр дүн</b>		<b>11,630,695,680.16</b>



Цемент шохой ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн  
тайланд хийсэн аудитын тайлан

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуриутлагдсан ашиг	Нийт дүн
2022 оны 4-р сарын 01-ний өдрийн үлдэгдэл	11,945,269,000.00	420,000,000.00	41,284,046,790.95	2,861,655,327.46	(150,048,718,737.87)	(93,537,747,619.46)
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-	-
<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>11,945,269,000.00</b>	<b>420,000,000.00</b>	<b>41,284,046,790.95</b>	<b>2,861,655,327.46</b>	<b>(150,048,718,737.87)</b>	<b>(93,537,747,619.46)</b>
Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал	-	-	-	-	11,630,695,680.16	11,630,695,680.16
<b>2022 оны 12-р сарын 31-ний өдрийн үлдэгдэл</b>	<b>11,945,269,000.00</b>	<b>420,000,000.00</b>	<b>41,284,046,790.95</b>	<b>2,861,655,327.46</b>	<b>(138,418,023,057.71)</b>	<b>(81,907,051,939.30)</b>



Цемент шохой ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн  
тайланд хийсэн аудитын тайлан

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 4-р сарын 01	2022 оны 12-р сарын 31
1	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
1.1	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>		<b>104,461,187,545.49</b>
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого		92,425,560,417.69
1.1.2	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		10,472,321.00
1.1.3	Буцаан авсан албан татвар		79,371,132.62
1.1.4	Бусад мөнгөн орлого		11,945,783,674.18
1.2	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>		<b>102,670,725,915.91</b>
1.2.1	Ажиллагчдад төлсөн		15,195,484,562.76
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн		9,992,942,432.10
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн		22,641,544,774.15
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн		10,502,455,235.44
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн		18,059,187,653.56
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн		217,160,000.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн		14,107,543,747.23
1.2.8	Даатгалын байгууллагад төлсөн		35,768,610.94
1.2.9	Бусад мөнгөн зарлага		12,352,958,899.73
1.3	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>		<b>1,790,461,629.58</b>
2	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
2.1	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>		<b>128,520,547.00</b>
2.1.1	Хүлээн авсан хүүний орлого		128,520,547.00
2.2	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>		<b>557,212,300.00</b>
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		557,212,300.00
2.2.2	Хөрөнгө оруулалтын буцаалт		-
2.3	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>		<b>(428,691,752.20)</b>
3	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
3.1	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>		<b>4,172,599,065.50</b>
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		4,161,100,709.98
3.1.2	Гадаад валютын ханшийн зөрүүний олз		11,498,355.52
3.2	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>		<b>672,120.00</b>
3.2.1	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз		672,120.00
3.3	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>		<b>4,171,926,945.50</b>
4	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>		<b>5,533,696,822.88</b>
5	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		<b>552,086,297.35</b>
6	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>6,085,783,120.23</b>



### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Цемент шохой ТӨХК-ийн хувьчлалын талаар авах арга хэмжээний тухай Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 3 дугаар 23-ны өдрийн 124 дүгээр тогтоолыг үндэслэн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын "Хувьчлалыг хүчингүйд тооцох, компанийн эрх, эд хөрөнгийг хүлээн авах тухай" 2022 оны 3 дугаар сарын 24-ны өдрийн 108 дугаар тогтоол гарч компанийн эрх, эд хөрөнгө төрийн өмчид шилжин ирсэн байна.

Цемент шохой ТӨХК нь Монгол улсын болон Олон улсын стандартад нийцсэн цемент, шохой үйлдвэрлэн дотоодын зах зээлийг бүрэн хангаж, экспортод гаргах, дулаан, барилгын засвар, засал чимэглэл, нийтийн хоол, зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх замаар ашигтай ажиллаж, үйлдвэрлэлийн ашигт ажиллагааг нэмэгдүүлэх, сайн чанарын бүтээгдэхүүн бий болгож, аюулгүй, тогтвортой хариуцлагатай барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлэн улс орны болон бүс нутгийн эдийн засгийн өсөлтөд хувь нэмрээ оруулах зорилготой үйлдвэрлэл эрхэлдэг, Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

Компанийн үндсэн зорилтыг хэрэгжүүлэх чиглэлээр дараах үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:

- Шохойн ордны хайгуул, судалгаа болон олборлолт, борлуулалтын үйл ажиллагаа;
- Барилгын материал цемент, шохой үйлдвэрлэх, борлуулах;
- Гадаад, дотоод худалдаа эрхлэх;
- Зөвхөн ажиллагсдын эрүүл мэнд, чийрэгжүүлэлтэд зориулсан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх;
- Зочид буудлын үйлчилгээ;
- Барилгын засвар, засал чимэглэлийн ажил, үйлчилгээ;

Цемент шохой ХК-ийн хувьцаа эзэмшигчийн 2018 оны ХЭШ-01/2018, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 18/02 тоот тогтоолын дагуу тус компанийн 100.0 хувийн хөрөнгө оруулалттай, гадаад худалдаа, барилгын засвар үйлчилгээ эрхлэх "Хөтөл Энержи Дулаан" ХХК-ийг нэг бүр нь 1,000.0 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 5,000 ширхэг энгийн хувьцаанаас бүрдэх хувь нийлүүлсэн хөрөнгөтэйгээр байгуулсан.

Хөтөл Энержи Дулаан ХХК нь Эрчим хүчний зохицуулах хорооны 2018 оны 326 дугаар тогтоолоор дулаан үйлдвэрлэх, түгээх, дулаанаар зохицуулалттай хангах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авч, Хөтөл хотын айл өрх, албан байгууллага, Цемент шохой ТӨХК-ийг дулааны эрчим хүч, халуун усаар хангах үйл ажиллагаа явуулж байна.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус компани нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Компанийн тухай хууль, Зөвшөөрлийн тухай хууль, Барилгын тухай хууль, Ашигт малтмалын тухай хууль, Эрчим хүчний тухай хууль, Төмөр замын тээврийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Иргэний тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд компанийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Төрийн хэмнэлтийн тухай хууль;
- Зөвшөөрлийн тухай хууль;
- Ашигт малтмалын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.7-д "уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчинд учирсан сөрөг нөлөөллийг тухай бүр бүртгэж, байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт болон тайланг жил бүр гарган байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн аймаг, сум, дүүргийн Засаг дарга, хяналт шалгалт хэрэгжүүлэх эрх бүхий байгууллагад тус тус хүргүүлэх бөгөөд уг тайланд дараах зүйлийг тусгах";



Компанийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны хэрэгжилт үр нөлөөгүй байна. Компанийн үйл ажиллагаанд тайлант онд Засгийн газрын хэрэг эрхлэх газар, ТУЗ-ийн дотоод аудитор, компанийн дотоод хяналтын хэлтсээс шалгалтууд хийгдэж илэрсэн алдаа, зөрчлийг арилгах зөвлөмж, мэдэгдэл, үүрэг даалгавруудын хэрэгжилт хангалтгүй байна.

ЗГХЭГ-аас тус компанийн 2022 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн байдлаарх үйл ажиллагаанд шалгалт хийж, 9 дүгээр сард шалгалтын тайланг танилцуулсан байна. Шалгалтаар төрийн өмчит компанийн эхлэлтийн тайлан гаргаж баталгаажуулаагүй, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан 12.5 тэрбум төгрөгийн 62 ажлыг хууль зөрчиж шууд худалдан авалт хийсэн, 2022 оны хөрөнгө оруулалтын болон үйл ажиллагааны төлөвлөгөөнд үндсэн үйл ажиллагаатай шууд холбоогүй 56.0 сая төгрөгийн үргүй зардал гаргасан, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй 313.5 сая төгрөгийн хөрөнгө худалдан авсан зэрэг зөрчлүүд илэрсэн байна. Цаашид алдаа зөрчлийг засаж сайжруулах арга хэмжээ авах талаар Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт 3, Төлөөлөн удирдах зөвлөлд 2, Гүйцэтгэх захиралд 5 асуудлаар үүрэг даалгавар өгсөн байна.

Тайлант онд ТУЗ-ийн дотоод аудитор компанийн 2022 оны санхүүгийн болон бусад үйл ажиллагаанд 16 чиглэлээр хяналт шалгалт хийх төлөвлөгөөг ТУЗ-ийн даргаар батлуулан хэрэгжүүлсэн байна. Шалгалтын үр дүнд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй, үргүй зардлууд гаргасан, худалдан авалтын гэрээ хийгдээгүй байхад урьдчилгаа төлбөр шилжүүлсэн, бараа материал хүлээлцсэн актгүй, бэлтгэн нийлүүлэгчийн төлбөр тооцооны үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, шилэн дансыг зохих ёсоор хөтлөөгүй, эдийн засгийн үндсэн үзүүлэлт зорилтот түвшний зардлын дэлгэрэнгүй төлөвлөгөө боловсруулаагүй зэрэг алдаа зөрчлүүд илрүүлж, гүйцэтгэх удирдлагад 4 мэдэгдэх хуудас, гүйцэтгэх захирал, газар нэгжүүдэд 25 зөвлөмж хүргүүлж ажилласан байна.

Гүйцэтгэх захирлын 2022 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн А/58 дугаар тушаалаар баталсан "Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам"-ын дагуу тайлант онд 5 чиглэлээр 21 асуудлыг шалгахад төлөвлөгөө боловсруулан батлуулсан. Нийт 26 хяналт хийснээс төлөвлөгөөнд тусгагдсан 21 асуудлыг багцлан төлөвлөгөөт 12, төлөвлөгөөт бус 14 шалгалт хийгдсэн байна. Шалгалтын үр дүнд нийт 66 зөвлөмжийг алба хэлтсүүдэд хүргүүлснээс хариу ирүүлэх хугацаа болоогүй 23, гүйцэтгэл 65.2 хувь байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Цемент шохой ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг Гүйцэтгэх захирлын 2015 оны 8 дугаар сарын 11-ний өдрийн 613 дугаар тушаалаар баталж, санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөж байна. Уг Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохироогүй байна.

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 124 дүгээр тогтоолыг үндэслэн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 108 дугаар тогтоолоор тус компанийн эрх, эд хөрөнгө төрд шилжин ирсэнтэй холбоотой нягтлан бодох бүртгэлийн зарим бодлогыг төрийн өмчийн холбогдох хууль тогтоомжид нийцүүлэх шаардлагатай байна.



### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

Цемент шохой ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн төрд хүлээн авсан эхний үлдэгдлээс 2.4 сая төгрөгөөр буюу 0.001 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	493.8	6,085.8	5,592.0
Авлага	10,342.7	11,061.0	718.3
Бараа материал	21,308.4	19,600.1	(1,708.3)
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	2,074.8	2,592.4	517.6
Борлуулах зорилгоор эзэмшиж байгаа эргэлтийн бус хөрөнгө	546.2	546.2	-
Үндсэн хөрөнгө	236,796.0	232,978.8	(3,817.2)
Биет бус хөрөнгө	5,412.0	5,300.6	(111.4)
Хойшлогдсон татварын хөрөнгө	1,188.6	-	(1,188.6)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>278,162.5</b>	<b>278,164.9</b>	<b>2.4</b>
Богино хугацаат өр төлбөр	51,439.5	36,471.4	(14,968.1)
Урт хугацаат өр төлбөр	320,260.7	323,600.5	3,339.8
Эздийн өмч	(93,537.7)	(81,907.0)	11,630.7
<b>Өр төлбөр ба эздийн өмчийн дүн</b>	<b>278,162.5</b>	<b>278,164.9</b>	<b>2.4</b>

Дээрх хүснэгтээс харахад төрд хүлээн авсан эхний үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, урьдчилж төлсөн зардал/тооцоо, үндсэн хөрөнгө, хойшлогдсон татварын хөрөнгө, богино болон урт хугацаат өр төлбөр, эздийн өмчийн дансуудад материаллаг дүнгээр өөрчлөлт гарсан байна.

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 6,085.8 сая төгрөг болж 5,592.0 сая төгрөгөөр өссөн нь төрд хүлээн авахын өмнө Худалдаа хөгжлийн банкнаас зээлийн төлөлт гэж хууль бусаар суутгасан 4,161.1 сая төгрөгийг 2022 оны 4 дүгээр сард буцаан авсан, цемент худалдах гэрээнээс 1,430.9 сая төгрөг урьдчилж орсон нь нөлөөлсөн байна.

Авлагын дансны үлдэгдэл нийт дүнгээр 11,061.0 сая төгрөг болж 718.3 сая төгрөгөөр өссөн байна. Үүнд дараах зүйлс нөлөөлсөн:

- Дансны авлага 966.2 сая төгрөгөөр буурсан нь борлуулалтын авлага барагдсанаар 977.7 сая төгрөгөөр буурч, ажиллагсдын авлага 11.5 сая төгрөгөөр өссөн;
- Татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн авлага 479.1 сая төгрөгөөр нэмэгдсэн нь нийгмийн даатгалын шимтгэлийг урьдчилж төлснөөс 260.5 сая, худалдан авалтын тооцооноос үүссэн нэмэгдсэн өртгийн албан татварын авлага 218.6 сая төгрөгөөр тус тус өссөн;
- Бусад авлага 1,205.4 сая төгрөгөөр өссөн нь олон жилийн насжилттай авлагыг тусад нь ангилж бүртгэсэн;

Бараа материалын дансны үлдэгдэл 19,600.1 сая төгрөг болж 1,708.3 сая төгрөгөөр буурсан нь төрийн өмчид хүлээж авах үеэс жилийн эцэст бэлэн бүтээгдэхүүн 116.5 сая, хагас боловсруулсан бүтээгдэхүүн 3,147.4 сая төгрөгөөр буурч, түүхий эд материал 262.1 сая, хангамжийн материалын нөөц 1,555.6 сая төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн байна.

Урьдчилж төлсөн тооцоо дансны үлдэгдэл 2,592.4 сая төгрөг болж 517.6 сая төгрөгөөр өссөн. Тайлант онд Дархан төмөрлөгийн үйлдвэрт төмрийн хүдэр худалдан авахаар тухайн оны



төсөвт өртгөөс 151.4 сая төгрөг илүү шилжүүлсэн, хууль хяналтын байгууллагад нэхэмжилсэн маргааны тэмдэгтийн хураамжинд 278.0 сая, Улаанбаатар төмөр зам компанид байршуулсан тээврийн хөлсний барьцаа 270.8 сая, импортын гаальд төлсөн 64.4 сая, 41 бэлтгэн нийлүүлэгчдэд 1,342.4 сая төгрөгийн урьдчилгаа төлж нийт 2,107.0 сая төгрөгөөр өссөн. Өмнөх үед үүссэн насжилт өндөртэй 32 харилцагчийн 707.5 сая төгрөгийн урьдчилгаа төлбөрийг ангилал шилжүүлэн бусад авлага дансанд шилжүүлж, худалдан авах гэрээний дүнд 31 харилцагчийн 881.9 сая төгрөгийн авлагыг барагдуулсанаар буурсан байна.

Борлуулах зорилготой эргэлтийн бус хөрөнгө дансанд 2017 онд шүүхийн шийдвэрээр өрөнд хүлээн авсан Дархан төмөрлөгийн үйлдвэрийн хашаанд байгаа 546.2 сая төгрөгийн өртөгтэй ККС-110 маркийн байшин краныг бүртгэсэн.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 232,978.8 сая төгрөг болж 3,817.2 сая төгрөгөөр буурсан нь тайлант онд худалдан авсан 3,280.3 сая, ТӨБЗГ-ын 341 дүгээр тогтоолоор ЭБЦТС ТӨХК-иас тээврийн хэрэгсэл шилжүүлэн авсан 85.3 сая, өрөндөө авсан механизм 666.5 сая төгрөгөөр нэмэгдэж, акталсан зөөврийн сууц 5.1 сая, тайлант оны элэгдлийн зардал 7,944.8 сая төгрөгөөр тус тус буурсан байна.

Биет бус хөрөнгө дансны үлдэгдэл 5,300.6 сая төгрөг болж 111.4 сая төгрөгөөр буурсан нь худалдаж авсан хөрөнгө 18.0 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант хугацааны хасагдуулгын зардал 129.4 сая төгрөгөөр буурсанаас шалтгаалжээ.

Хойшлогдсон татварын хөрөнгийн дансанд 2017 оноос хуримтлагдсан 1,188.6 сая төгрөгийг тайлант онд Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2-д "Харьяалах татварын албаар баталгаажуулсан ирээдүйд шилжүүлэн тооцох алдагдлыг тухайн алдагдал гарсан татварын жилийн дараах дараалсан дөрвөн жил бүр албан татвар ногдуулах орлогын нийт дүнгийн 50.0 хувиар хязгаарлан хасаж тооцно" гэсэн заалтын дагуу тайлант үеийн орлогын албан татварын өглөгийг бууруулан бүртгэсэн.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 36,471.4 сая төгрөг болж нийт 14,968.1 сая төгрөгөөр буурсан. Үүнд:

- Дансны өглөгийн үлдэгдэл бэлтгэн нийлүүлэгчийн тооцоог барагдуулж 3,620.4 сая;
- Цалингийн 3 дугаар сарын өглөгийг сар дамжуулан олгосон 977.6 сая;
- Төрд хүлээн авч татварын өр төлбөрийг барагдуулсан 4,948.2 сая;
- Нийгмийн даатгалын шимтгэлийн өр төлбөрийг барагдуулсан 5,740.2 сая;
- Урамшууллын сангийн нөөц өр төлбөр данснаас ажиллагсдын тэмцээн уралдааны зардалд 25.5 сая төгрөгийг тус тус зарцуулсан;
- Хүүний өглөг дансанд суутгаж авсан 217.1 сая төгрөг буцаж орсон;
- Урьдчилж орсон орлого тайлант онд 126.7 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн.

Нийт богино хугацаат өр төлбөрийн үлдэгдлийн 45.0 хувь буюу 16,372.6 сая төгрөг нь Худалдаа хөгжлийн банкны 4 зээлийн гэрээнд хамаарах хүүгийн өглөг, 35.0 хувь буюу 12,703.3 сая төгрөг нь 5 төрлийн татварын өр, 1.0 хувь буюу байгууллагад өгөх өглөг 249.0 сая төгрөг нь төрд хүлээн авахаас өмнөх үед үүссэн байна.

Тайлант онд үүссэн 961 харилцагчаас цемент нийлүүлэх гэрээний урьдчилгаа төлбөр 3,952.8 сая төгрөгийн өглөг 11.0 хувь, худалдан авах ажиллагаанаас 55 бэлтгэн нийлүүлэгчдийн 3,194.7 сая төгрөгийн өглөг нь 8.0 хувийг эзэлж байна.

Урт хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 323,600.5 сая төгрөг болж 3,339.8 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Үүнд:

- Урт хугацаат зээлийн дансны үлдэгдэл 4,161.1 сая төгрөгөөр нэмэгдсэн нь төрд хүлээн авахаас өмнөх үеийн Худалдаа хөгжлийн банкнаас авсан 4 зээлийн гэрээний төлбөрт суутгасан төлбөрийг 4 дүгээр сард буцаан авсан;
- Байгаль орчны нөхөн сэргээлтийн нөөц дансны үлдэгдэл өмнөх үеийн байгаль орчныг нөхөн сэргээх зардлыг залруулсан 482.2 сая төгрөгөөр буурсан;
- Хойшлогдсон татварын өрийн данс тайлант үеийн татварын зардлын тооцооллоор 339.2 сая төгрөгөөр буурсан.



Эздийн өмчийн 11,630.70 сая төгрөгийн өсөлт нь 2022 онд толгой компани 12,559.1 сая төгрөгийн ашигтай ажилласан хуримтлагдсан алдагдлын бууралт болон охин компанийн 928.4 сая төгрөгийн алдагдал зэрэг нөлөөлсөн байна.

Цемент шохой ТӨХК-ийн орлогын дэлгэрэнгүй тайлангаар нийт орлого 83,147.1 сая төгрөг тайлагнасан. Үүнд:

- Цементийн борлуулалтын орлого 70,421.4 сая;
- Шохойн борлуулалтын орлого 9,946.7 сая;
- Дулаанаар зохицуулалттай хангах үйлчилгээний орлого 919.5 сая;
- Үйл ажиллагааны бусад орлого 1,187.0 сая;
- Үндсэн бус үйл ажиллагааны орлого 672.5 сая төгрөг байна.

Тайлант онд нийт 68,540.8 сая төгрөгийн өртөг, зардал тайлагнасан байна. Үүнд:

- Борлуулсан бүтээгдэхүүний өртөг 62,463.2 сая;
- Борлуулалт маркетингийн зардал 1,984.4 сая;
- Ерөнхий ба удирдлагын зардал 2,607.1 сая;
- Бусад зардал 1,486.1 сая;
- Орлогын албан татварын зардал 2,986.4 сая төгрөг байна.

### 3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Цемент шохой ТӨХК нь эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө боловсруулж, ТУЗ-аар дэмжүүлэн ТӨБЗГ-аар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Компанийн 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг ТӨБЗГ-ын 2022 оны 5 дугаар сарын 253 дугаар тогтоолоор баталсан байна. Төлөвлөгөөнд төрд хүлээн авахаас өмнөх 3 сарын гүйцэтгэлийг нэмж оруулан жилийн дүнгээр батлуулсан. Тайлант оны нийт орлогыг 104,861.3 сая төгрөгөөр, нийт зардлыг 85,494.6 сая төгрөгөөр, 19,366.7 сая төгрөгийн ашигтай ажиллахаар тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 10,863.5 сая төгрөгийг төлөвлөсөн байна.

ТӨБЗГ-ын 2022 оны 9 дүгээр сарын 19-ний өдрийн 387 дугаар тогтоолоор тус компанийн 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тодотгол хийж баталсан байна. Тайлант оны орлогыг 7,699.4 сая төгрөгөөр бууруулан 97,161.9 сая төгрөгөөр, нийт зардлыг 1,812.6 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 87,307.2 сая төгрөгөөр, нийт ашгийг 9,512.0 сая төгрөгөөр бууруулан 9,854.7 сая төгрөг болгон тодотгосон байна. Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 59 нэр төрлийн ажилд өөрийн эх үүсвэрээс 11,760.4 сая төгрөгийг зарцуулахаар тодотгосон байна.

Тодотгол хийх болсон шалтгаан нь:

1. Цементийн үндсэн түүхий эд болох чулуунцарын үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд доголдол үүсэж 42 хоногийн тэг зогсолт болж, бүтээгдэхүүн үйлдвэрлэл болон борлуулалт зогссон.
2. Охин компани болох Хөтөл Энержи Дулаан ХХК-ийн орлого, зардал, хөрөнгө оруулалтыг нэмж оруулж батлуулсан.

Гүйцэтгэлээр тайлант онд 100,292.6 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 85,851.1 сая төгрөгийн зардал гарган, 14,441.5 сая төгрөгийн татварын өмнөх ашигтай ажилласан байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний 32 нэр төрлийн ажилд өөрийн эх үүсвэрээс 7,921.1 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна.



## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Цемент шохой ТӨХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд Цемент шохой ТӨХК, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн компанийн үйл ажиллагааг сайжруулах нягтлан бодох бүртгэлийн зарим бодлогод өөрчлөлт оруулах, нөөц сангийн бүртгэлд мөрдөх журмыг төрийн өмчийн хууль тогтоомжид нийцүүлэн шинэчлэх, үндсэн хөрөнгийн ашиглалтыг сайжруулах, хөрөнгүүдийг бодитой үнэлэн бүртгэх, нягтлан бодох бүртгэл санхүүгийн тайлагналыг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Ди Эй Би Жи Аудит ХХК-ийн аудитор Ө.Ундармаа, С.Цэнгэлмаа, Э.Цэрэннадмид, туслах аудитор Б.Бямбатогтох нар гүйцэтгэж, хяналтыг захирал Н.Дэлгэрмаа, чанарын хяналтын менежер О.Уранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Цемент шохой ТӨХК нь 2022 оны санхүүгийн тайлангаа Үндэсний аудитын газарт 2023 оны 3 дугаар сарын 07-ны өдрийн 01/227 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

Гүйцэтгэх захирлын 2023 оны 3 дугаар сарын 01-ний өдрийн Б/208 дугаар тушаалаар Ерөнхий нягтлан бодогч бөгөөд санхүү, удирдлагын газрын даргыг ажлаас чөлөөлсөн нь нөлөөлж, жилийн эцсийн тайланг хуулийн хугацаанд ирүүлээгүй, хугацаа хоцроосон.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний нийт орлогын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл их гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны батлагдсан орлогын төлөвлөгөөний 97,161.9 сая төгрөгөөс 0.5 хувиар буюу 485.8 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 124, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 108 дугаар тогтоолын дагуу компанийн эрх, эд хөрөнгийг төрд хүлээн авч компанийн ТУЗ-ийн 2022 оны 4 дүгээр сарын 06-ны өдрийн 1 дүгээр тогтоолоор компанийн бүтэц зохион байгуулалт, орон тооны дээд хязгаарыг 768 байхаар баталсан байна.

ТУЗ-ийн 2022 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн 4 дүгээр тогтоолоор 3 орлогч захирлын орон тоог цомхотгон бүтэц орон тоог шинэчлэн, орон тооны дээд хязгаарыг 765 байхаар баталсан ч, байгууллага дотроо өөр албан тушаалд томилогдож зардал хэмнээгүй байна.

Тайлант онд бараа материалын 816.9 сая төгрөгийн илүүдэл нөөц бэлтгэсэн, оффисын байрны түрээст нормативт хэмжээ болон үнийн тарифыг хэтрүүлэн зарцуулсан 53.7 сая, байгууллага, спортын холбоо зэрэгт хандив тусламж, спорт урлагийн баяр наадам, орон нутгийн хайрхан бумба тахисан 183.5 сая, зориулалт бусаар 119.0 сая төгрөгийг зарцуулж Төрийн хэмнэлтийн хуулийг хэрэгжүүлээгүй нийт 1,158.7 сая төгрөгийн зөрчилд байгууллагын хохирлыг барагдуулах 64.1 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 1,109.0 сая төгрөгийг тэвчиж болох зардал зарцуулсныг засаж сайжруулах албан шаардлага хүргүүлсэн.



#### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 21 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Цемент шохой ТӨХК нь тайлант оны 4-12 дугаар сард шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулбал зохих 168,166.9 сая төгрөгийн нийт 115 мэдээллээс 60 мэдээлэл хугацаанд нь байршуулж, 3 мэдээ хугацаа болоогүй, 72,050.2 сая төгрөгийн 50 мэдээллийг хугацаа хоцроож, дараа жилийн төсвийн төсөл, аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний 2 мэдээллийг огт мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3 "тогтоосон хугацаанд тогтмол шуурхай оруулж байх", Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам"-ын холбогдох заалтуудтай тус тус нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах, зөрчлийг арилгаж давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх.

##### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант онд хийгдсэн худалдан авалтын үйл ажиллагааг батлагдсан төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлсэн эсэхийг тендерийн баримт материалтай тулган шалгахад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Худалдан авалтын төлөвлөгөөнд нээлттэй тендер шалгаруулахаар баталсан боловч 11,746.5 сая төгрөгийн 9 удаагийн худалдан авалтыг шууд гэрээ байгуулсан, төлөвлөгөөнд батлаагүй, дээд газрын шийдвэргүй 1 удаагийн 300.0 сая төгрөгийн худалдан авалт хийсэн, 262.3 сая төгрөгийн шууд худалдан авалт нь төлөвлөгөөнд байгаа ч оны эцэст тайлагнаагүй;
- Өмгөөллийн зөвлөх үйлчилгээний 254.1 сая төгрөгийн худалдан авалтыг 13 салгаж шууд худалдан авалт хийсэн, ажил гүйцэтгэх гэрээнүүдийн үр дүн гараагүй үргэлжилж байгаа, 35.0 сая төгрөгийн авлагыг барагдуулахад зориулж 37.8 сая төгрөгийн гэрээ байгуулсан;
- Худалдан авалтын төлөвлөгөөнд батлуулаагүй, нээлттэй тендер шалгаруулах босго давсан 2,187.9 сая төгрөгийн 11 гэрээ, харьцуулалтын аргын босго 645.7 сая төгрөгийн 16 гэрээг шууд худалдан авалт хийсэн, гэрээг аудитад ирүүлээгүй;
- Хөтөл Энержи Дулаан ХХК-ийн 1,885.7 сая төгрөгийн 3 худалдан авалт, Цемент шохой ТӨХК-ийн 3,867.7 сая төгрөгийн 2 худалдан авалтыг босго үнийг харгалзахгүйгээр шууд гэрээ байгуулахаар, Байгаль орчны дүйцүүлэн хамгаалалын 158.7 сая төгрөгийн гэрээний худалдан авалтыг харьцуулалтын аргаар хийхээр тус тус төлөвлөгөөнд батлуулсан.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1-д "төрийн аудитын байгууллагын аудит хийхэд шаардагдах цаасан болон цахим хэлбэрийн мэдээлэл, баримт бичгээр хангах, уг мэдээлэл, баримт бичгийн үнэн зөв, бодитой, бүрэн байх шаардлагыг хариуцах", ТБОНӨ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2-д "үйлдвэрийн газрын нэрийн өмнөөс эд хөрөнгийг энэ хууль, гэрээнд заасан эрх хэмжээний дотор захиран зарцуулах", 20.7-д "тогтоосон журмын дагуу



анхан шатны бүртгэлийг хөтөлж нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцэл, статистикийн мэдээ гаргах ажлыг зохион байгуулж, тэдгээрийн үнэн зөвийг хариуцах", ТБОНӨХБАУХАТХ-ийн 8 дугаар зүйл, МУЗГ-ын 2021 оны 124-р тогтоолоор баталсан "ТБОНӨХБАУХАА-ны журмыг сонгоход баримтлах босго үнэ" гэсэнтэй тус тус нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: ТБОНӨХБАУХА тухай хуулийг мөрдөж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомж, худалдан авах ажиллагаа нь ТБОНӨХБАУХА тухай хууль тогтоомжийн заалттай тус тус нийцээгүй байна гэж дүгнэлээ.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Аудитын нээлтийг 2023 оны 1 дүгээр сарын 11-ний өдөр хийж аудитыг эхлүүлсэн. Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 124 дүгээр тогтоолыг үндэслэн ТӨБЗГ-ын 2022 оны 108 дугаар тогтоолоор тус компанийн хувьчлалыг буцаан төрийн өмчид авахаар шийдвэрлэснийг өмнөх удирдлагууд хүлээн аваагүй, компанийн эрх, эд хөрөнгийг 2 тал хүлээлцсэн акт хийгдээгүй. Төрийн өмчит компанийн эхлэлтийн тайлан гаргаж төсвийн ерөнхийлөн захирагчийн Э-тайланд баталгаажуулаагүй байсан.

Завсрын аудитаар төрд шилжин ирсэн эхлэлтийн тайлангийн үзүүлэлтүүдийг баталгаажуулах ажлыг хийсэн. Цемент шохой ТӨХК нь 2023 оны 3 дугаар сарын 03-ны өдөр эхлэлтийн тайлан гаргаж, Барилга, хот байгуулалтын яамны Э-Тайлангийн цахим системд тайлагнасан.

##### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Хувийн хэвшлийн эзэмшилд байсан Хөтөлийн Цемент шохой ХК-ийн өмнөх оны санхүүгийн тайланд төрийн аудитын байгууллага аудит хийгээгүй тул аудитын зөвлөмж өгөгдөөгүй байна.

#### **4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Компанийн санхүү, худалдан авах ажиллагаанд төрийн хэмнэлтийн болон төрийн өмчийн хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй, тайлант онд Засгийн газрын хэрэг эрхлэх газар, ТУЗ-ийн дотоод аудитор, компаний дотоод хяналтын хэлтсээс шалгалтууд хийгдэж илэрсэн алдаа, зөрчлийг жилийн эцсийн аудитаар засаагүй байгаа тул Үндэсний Аудитын газраас гүйцэтгэлийн аудит хийх шаардлагатай.

Компанийн Эдийн засгийн үндсэн үзүүлэлт зорилтот түвшний төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланг санхүүгийн тайлангийн үзүүлэлттэй уялдуулан үнэн зөв тайлагнасан эсэх, үйлдвэрлэлийн шат дамжлага бүрийн үйлдвэрлэсэн тоо хэмжээ, өртөг зардлыг зөв тооцоолон хуваарилан бүртгэж тайлагнасныг дараагийн аудитаар авч үзнэ.



## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 338,348.6 сая төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад 287,160.2 сая төгрөгийн алдааг залруулж, 51,188.4 сая төгрөгийн алдааг дахин давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

Аудитаар илэрсэн 287,160.2 сая төгрөгийн нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой алдаа илэрснийг залруулж санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав.

Үүнд:

- Санхүүгийн байдлын тайлангийн эхний үлдэгдэлд өмчийн дансанд Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 173 дугаар тогтоолоор хүчингүй болгосон хувьцааны 275,738.8 сая төгрөгийг илүү бүртгэснийг урт хугацаат хөрөнгө оруулалтын өглөг дансанд шилжүүлж;
- Урт хугацаат хөрөнгө оруулалтын дансанд охин компанид оруулсан хөрөнгө 3,110.3 сая;
- Бусад авлага дансанд охин компанид санхүүжилт олгосон 4,226.0 сая;
- Санхүүгийн байдлын тайлангийн эцсийн үлдэгдэлд охин компанийн хөрөнгө оруулалтад 341.6 сая төгрөгийг хасагдуулан бүртгэснийг бусад авлага дансанд буцаан залруулж;
- Тайлант онд охин компанид санхүүжилт олгосон 2,196.3 сая төгрөгийг бусад авлагын дансанд давхардуулан бүртгэсэн;
- Орлогын дэлгэрэнгүй тайланд холбоотой талуудын хоорондын борлуулалт 1,547.2 сая төгрөгийг давхардуулан тайлагнасан;

Аудитаар нийт 462,551.8 сая төгрөгийн зөрчил илэрснээс, 64.1 сая төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 462,487.7 сая төгрөгийн 6 албан шаардлага хүргүүлсэн.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн 462,551.8 сая төгрөгийн зөрчил нь тогтоосон 485.8 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс их, санхүүгийн тайланд үзүүлэх мэдэгдэхүйц нөлөөтэй байгаа тул Сөрөг дүгнэлт өглөө.

### 5.1 Төлбөрийн акт

1. Гүйцэтгэх захирлын хувийн зардалд 6.4 сая, Улаанбаатар оффисын үйл ажиллагаанд батлагдсан төлөвлөгөөнд тусгаагүй 27.0 сая төгрөгийг зарцуулсан бөгөөд анхан шатны баримтын бүрдэл дутуу /хоол, ундаа, кофены баримт хавсаргасан/, хайрхан тахисан, бумбын баярт оролцсон 5.9 сая, томилолтын зардлыг Сангийн сайдын тушаалаар баталсан хэмжээнээс илүү, Улаанбаатар хотод ажлын байртай ажилтнуудад Хөтөлөөс-УБ гэсэн маршрутаар томилолтын зардалд 7.7 сая олгосон, баримтаар нотлогдоогүй ажилчдын хор саармагжуулах гэсэн гүйлгээний утгатай 11.0 сая төгрөгийг барилгын компанид шилжүүлсэн зэрэг нийт 58.0 сая төгрөгийн үргүй зардал гарсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.3-д "Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр хандивлах, бэлэглэх, барьцаалах, зээлдүүлэх, бусад өмчийн хуулийн этгээдэд хувь хөрөнгө болгон оруулахыг хориглоно", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгохыг хориглоно", 15.1.7-д "байгууллагын төсвөөр согтууруулах ундаа худалдан авах" гэсэнтэй тус тус нийцээгүй, санхүүгийн тайлангийн үнэлгээ ба хуваарилалт, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж үргүй зарцуулсан хөрөнгийг буруутай шийдвэр гаргасан албан тушаалтнаар нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

2. Хөтөл Энержи Дулаан ХХК-ийн удирдлага тайлант онд томилолтын зардалд 2.6 сая илүү зарцуулсан, урлагийн бага наадамд 0.9 сая, улсын баяр наадамд 0.8 сая, барилгачдын баярт 1.8 сая, нийт 6.1 сая төгрөгийг тус тус үргүй зарцуулсан, энэ нь цахим И-баримтаар нотлогдоогүй байна.



Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.3-д "Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр хандивлах, бэлэглэх, барьцаалах, зээлдүүлэх, бусад өмчийн хуулийн этгээдэд хувь хөрөнгө болгон оруулахыг хориглоно", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгохыг хориглоно" гэсэнтэй тус тус нийцээгүй, санхүүгийн тайлангийн үнэлгээ ба хуваарилалт, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж үргүй зарцуулсан хөрөнгийг буруутай шийдвэр гаргасан албан тушаалтнаар нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

## 5.2 Албан шаардлага

1. Компанийн 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланд төрд шилжин ирсэн үеийн хугацааны 70,072.4 сая төгрөгийн зарцуулалт тайлагнасан ч төлөвлөгөөний үзүүлэлтийг харгалзах хугацаагаар зэрэгцүүлээгүй, санхүүгийн тайлангийн тоо хэмжээ, өртөгтэй уялдуулаагүй, бодитой, ил тод тайлагнаагүй.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.8-д "Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн жилийн тайлан нь түүний зорилтын саналтай харьцуулан дүгнэж болох ижил үзүүлэлттэй байх бөгөөд шаардлагатай мэдээллийг агуулсан байна" гэсэнтэй нийцээгүй, санхүүгийн тайлангийн тасалбар болголт, толилуулга батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Компанийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний гүйцэтгэлийг ижил хугацаанд зэрэгцүүлэн үнэн зөв тайлагнах, тайлангийн хэрэглэгчдийг үнэн зөв мэдээллээр хангах албан шаардлага өгөв.

2. Санхүүгийн тайлангийн эхний үлдэгдэлд шүүхийн шийдвэр гараагүй маргаантай урт хугацаат банкны зээлийн өглөг 41,916.8 сая, зээлийн хүүгийн өглөг 16,372.6 сая, хуучнаар Цемент шохой ХК-ийн удирдлага төрийн шийдвэрийг эс зөвшөөрч, хоёр тал хүлээлцээгүй урт хугацаат хөрөнгө оруулалтын өглөг 275,738.8 сая, нэмж төлөгдсөн капитал 420.0 сая, эздийн өмчийн бусад хэсэг 2,861.6 сая төгрөг бүртгэлтэй байна.

Тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй олон жилийн насжилттай авлага 42,964.1 сая, урьдчилж төлсөн тооцоо 758.7 сая, урьдчилж орсон орлого 171.8 сая, богино хугацаат өглөг 238.1 сая төгрөгийг тайлагнасан.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 3 дахь заалт "Хувьчлал хүчингүй болсон тохиолдолд ТӨБЗ-ын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага уг зөрчлөөс үүссэн хохирлыг арилгах, эд хөрөнгийг хамгаалах арга хэмжээ авч, цаашид уг эд хөрөнгийг хэрхэх тухай шийдвэр гаргана", 71 дүгээр зүйлийн 71.8-д "өр авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэнтэй тус тус нийцээгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангаагүй байна

Шийдвэрлэсэн нь: Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн өмч хөрөнгийн маргааныг шийдвэрлэхэд анхаарах, өмгөөллийн зөвлөх үйлчилгээний ажлын үр дүнг тооцох, өмнөх үеийн авлагыг хууль хяналтын байгууллагад шилжүүлэн барагдуулах арга хэмжээ авах албан шаардлага өгөв.

3. Байгууллагын эзэмшлийн 27 газрыг санхүүгийн тайланд биет бус хөрөнгөөр үнэлж бүртгээгүй, Эргэлтийн хөрөнгөнд бүртгэлтэй 546.2 сая төгрөгийн өртөгтэй борлуулах зорилготой ККС-110 маркийн байшин кран байгууллагын эзэмшилд биетээр оршин байхгүй.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар,



энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", ТБОНӨ-ийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-д "Төрийн өмчит хуулийн этгээд эзэмшилдээ байгаа илүүдэл үндсэн эд хөрөнгө, түүнчлэн ашиглах хугацаа нь дууссан буюу эсхүл осол гэмтэлд өртсөний улмаас зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон бөгөөд засаж, сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тооцоогоор нотлогдсон эд хөрөнгийг худалдаж, шилжүүлж, акт тогтоон устгаж болно" гэсэнтэй тус тус нийцээгүй, санхүүгийн тайлангийн оршин байх, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын хөрөнгийг бүртгэлд бүрэн тусгах, хадгалалт хамгаалалтыг сайжруулах арга хэмжээ авах албан шаардлага өгөв.

4. Худалдан авалтын нээлттэй тендер шалгаруулсан 3 ажлын 908.8 сая, харьцуулалтын 3 ажлын 207.5 сая төгрөгийн худалдан авалтын гэрээнүүдийг аудитад ирүүлээгүй, мөн 16 ажлын 5,890.3 сая төгрөгийн гэрээг дүгнэсэн актгүй, худалдан авалтын гэрээний хэрэгжилтэд нийт 7,006.6 сая төгрөгийн зөрчилтэй. Тайлант онд бэлтгэн нийлүүлэгчдэд дээрх гэрээнүүдийн төлбөр 4,191.6 сая төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 16.1.1-д "төрийн аудитын байгууллагын аудит хийхэд шаардагдах цаасан болон цахим хэлбэрийн мэдээлэл, баримт бичгээр хангах, уг мэдээлэл, баримт бичгийн үнэн зөв, бодитой, бүрэн байх шаардлагыг хариуцах"; ТБОНӨХБАҮХАТХ-ийн 49.2.10-д "гэрээг дүгнэж, бараа, ажил, үйлчилгээг хүлээж авсан баримт бичиг", НББ-ийн тухай хуулийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэнтэй тус тус нийцээгүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авалтын гэрээний хэрэгжилтийг үнэлж, дүгнэн, баримт материалын холбогдох хууль, журмын дагуу бүрдүүлэн архивлан ажиллах, цаашид үйл ажиллагаандаа хууль, журмыг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага өгөв.

5. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжүүлээгүй дараах зөрчлүүд байна. Үүнд:

- Бараа материалын дансанд тайлант оны 4-12 сарын хугацаанд яаралтай ашиглагдахгүй 816.9 сая төгрөгийн бараа материалын худалдан авалт хийж, зарцуулагдаагүй их хэмжээний үлдэгдэл байна.

- Гүйцэтгэх захирал, газар хэлтсийн дарга нар 7 хүн Дархан аймагт амьдрах байр түрээсэлж, 40.5 сая төгрөгийг байгууллагаас төлсөн. Улаанбаатар хотод компанийн төлөөлөгчийн газарт ТӨБЗГ-ын зөвшөөрөлгүй 206.4 м<sup>2</sup> талбай бүхий байрыг 1м<sup>2</sup>-г 66.000 төгрөгөөр үнэлж түрээсэлсэн. Түрээсийн үнэ Засгийн газрын тогтоолоор баталсан үнэлгээнээс хэт өндөр 53.7 сая төгрөгийн илүү зардал гаргасан.

- Компаниас эдийн засгийн форумд 66.2 сая, урлагийн наадам 10.2 сая, хөлбөмбөгийн талбай тохижуулахад 25.6 сая, 3х3 сагсан бөмбөгийн талбай тохижуулахад 22.3 сая, Сэлэнгэ аймгийн жудо бөхийн холбоо, 2-р цэцэрлэг, Орхон сумын ЗДТГ зэрэгт 26.1 сая, барилгачдын баярт 33.1 сая, хүлээн авалтын зардалд 14.4 сая төгрөгийг тус тус зарцуулж, нийт 1,109.2 сая төгрөгийн тэвчиж болох зардал гаргасан.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.3-д "Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр хандивлах, бэлэглэх, барьцаалах, зээлдүүлэх, бусад өмчийн хуулийн этгээдэд хувь хөрөнгө болгон оруулахыг хориглоно", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.1-д "зардал бууруулахад чиглэсэн арга хэмжээг энгийн ойлгомжтой, тууштай, сахилга баттайгаар зохион байгуулах", 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгохыг хориглоно", 15.1.6-д "нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа материал бэлтгэх, нөөцлөхийг хориглоно" гэсэнтэй тус тус нийцээгүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах, дээд газраас зохих зөвшөөрөл авах, цаашид үйл ажиллагаандаа хууль, журмыг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага өгөх.



6. Охин компани Хөтөл Энержи Дулаан ХХК-тай холбоотой нийт 2,310.8 сая төгрөгийн дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- Дулаан, нүүрсний борлуулалтын авлага болон бусад авлагын үлдэгдэл 1,082.2 сая төгрөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй,

- Бараа, ажил, үйлчилгээний худалдан авалтын 1,183.1 сая, зөвлөх үйлчилгээний 40.0 сая, нийт 1,223.1 сая төгрөгийн гэрээг дүгнэж, акт үйлдээгүй,

- Боруулалтын нягтлан бодогч, байцаагч, нярвуудын цалинг 2022 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс үндэслэлгүй бууруулж, батлагдсан цалингийн хэмжээнээс нийт 5.5 сая төгрөгийн дутуу цалин олгосон.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2-д "үйлдвэрийн газрын нэрийн өмнөөс эд хөрөнгийг энэ хууль, гэрээнд заасан эрх хэмжээний дотор захиран зарцуулах", 20.4-д "үйлдвэрийн газрын захиргааны бүтцийг тогтоож, албан тушаалтныг томилох, чөлөөлөх, эрх бүхий байгууллагаас тогтоосон цалингийн бүдүүвч сангийн хэмжээнд багтаан цалинг тогтоох", 71 дүгээр зүйлийн 71.8-д "өр авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.2.10 "гэрээг дүгнэж, бараа, ажил, үйлчилгээг хүлээж авсан баримт бичгийг тендерийн хавтаст хэрэгт бүрдүүлнэ", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэнтэй тус тус нийцээгүй, санхүүгийн тайлангийн иж бүрэн, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах, цаашид үйл ажиллагаандаа хууль, журмыг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага өгөх.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлагналтай холбоотой асуудал

##### Илрүүлэлт:

Санхүүгийн тайлангийн эхний үлдэгдэлд Хойшлогдсон татварын хөрөнгө 1,188.6 сая, хойшлогдсон татварын өр 4,042.8 сая, урамшууллын сан 42.1 сая, байгаль орчны нөхөн сэргээлтийн нөөц сан 2,695.6 сая төгрөгийг тус тус баталгаажуулаагүй тайлагнасан. Мөн 2015 онд баталсан журмын дагуу 1-3 жилийн насжилттай авлагуудыг зардлаар бүртгэн байгуулсан 36,834.0 сая төгрөгийн Найдваргүй авлагын нөөц санг тайлагнасан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын 37.59-д "нөөцийг тухайн тайлант үе бүрийн эцэст нягталж, шалгах бөгөөд одоогийн хамгийн сайн тооцооллыг тусгахын тулд түүнийг тохируулна. Хэрэв үүргийг барагдуулахад шаардагдах эдийн засгийн үр өгөөж бүхий нөөцийг зарцуулах магадлал цаашид үгүй болвол уг нөөцийг буцаана", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4-д "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" гэсэнтэй тус тус нийцээгүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангаагүй байна.

##### Өгсөн зөвлөмж:

Төрийн өмчийн тухай хууль тогтоомжид нийцүүлэн журмуудыг шинэчлэн мөрдөх, нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт оруулах, татварын тооцооллыг нягтлан бүртгэлд тусгах.



## **2. Хөтөл-Энержи дулаан ХХК-ийн санхүүгийн тайлагналтай холбоотой асуудал**

### Илрүүлэлт:

Санхүүгийн тайланд орлогыг аккруэль сууриар тайлагнаагүй 1.0 сая, өр төлбөрийн үлдэгдлийг татвар шимтгэлийн тайлангаас 17.7 сая, бараа материалын тодруулгаас 13.9, нийт 32.6 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "аж ахуйн нэгж байгууллага нягтлан бодох бүртгэлийг аккруэл сууриар хөтөлнө", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэнтэй тус тус нийцээгүй, санхүүгийн тайлангийн тасалбар болголт, толилуулга батламж мэдэгдлийг хангаагүй байна.

### Өгсөн зөвлөмж:

Төрийн өмчийн тухай хууль тогтоомжид нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт оруулах, залруулан тайлагнах.

## **3. Үндсэн хөрөнгийн ашиглалттай холбоотой асуудал**

### Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэлд бүртгэлтэй 6,352.7 сая төгрөгийн ашиглалтын хугацаа дууссан, ашиглах боломжгүй эвдэрч гэмтсэн хөрөнгүүд бүртгэлтэй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-д "Төрийн өмчит хуулийн этгээд эзэмшилдээ байгаа илүүдэл үндсэн эд хөрөнгө, түүнчлэн ашиглах хугацаа нь дууссан буюу эсхүл осол гэмтэлд өртсөний улмаас зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон бөгөөд засаж, сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тооцоогоор нотлогдсон эд хөрөнгийг худалдаж, шилжүүлж, акт тогтоон устгаж болно" гэсэнтэй тус тус нийцээгүй, санхүүгийн тайлангийн оршин байх, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангаагүй байна

### Өгсөн зөвлөмж:

Байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөл, Гүйцэтгэх захирлын тодорхойлолт шийдвэрийг үндэслэн ТӨБЗГ-т актлах, данснаас хасах хүсэлт гаргаж хөрөнгийг шийдвэрлүүлэх, байгууллагын хөрөнгийг бодитой үнэлэн бүртгэх.

Дээрх зөвлөмж, төлбөрийн акт, албан шаардлагын биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 9 дүгээр сарын 01 -ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



Цемент шохой ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Д.д	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Тоо	Дүн	
										Залруулагүй	Тоо			Дүн
<b>ЦЕМЕНТ ШОХОЙ ТӨХК</b>														
1	Нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлангийн эхний үлдэгдэлд 283,075.1 сая, эцсийн үлдэгдэлд 2,537.9 сая, орлогын дэлгэрэнгүй тайлангийн тайлант үед 1,547.2 сая төгрөгийг давхардуулан тайлагнасан.	1	287,160.2			1	287,160.2							
2	Санхүүгийн тайлангийн эхний үлдэгдэлд Хойшлогдсон татварын хөрөнгө 1,188.6 сая, хойшлогдсон татварын өр 4,042.8 сая төгрөгийг баталгаажуулаагүй 2020 онд байгуулсан урамшууллын сан 42.1 сая, байгаль орчны нөхөн сэргээлтийн нөөц сан 2,695.6 сая төгрөгийг тус тус баталгаажуулаагүй тайлагнасан 2015 онд баталсан журмын дагуу 1-3 жилийн насжилттай авлагуудыг зардлаар бүртгэн байгуулсан 36,834.0 сая төгрөгийн Найдваргүй авлагын нөөц санг тайлагнасан	1	5,231.4										1	2,737.7
3	Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэлд бүртгэлтэй 6,352.7 сая төгрөгийн ашиглалтын хугацаа дууссан, ашиглах боломжгүй эвдэрч гэмтсэн хөрөнгүүд бүртгэлтэй байна.	1	6,352.7										1	6,352.7
<b>ХӨТӨЛ ЭНЕРЖИ ДУЛААН ХХК</b>														



Цемент шохой ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

4	Санхүүгийн тайланд орлогыг акруэль сууриар тайлагнаагүй 1.0 сая, өр төлбөрийн үлдэгдлийг татвар шимтгэлийн тайлангаас 17.7 сая, бараа материалын тодруулгаас 13.9, нийт 32.6 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан.	1	32.6	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		Тоо
	Дүн	4	338,348.6	-	-	1	287,160.2	1	287,160.2	-	-	3	51,188.4

6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Д.Д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил				Албан шаардлага				Зөвлөмж				Хариуцлага тооцуулах албан шаардлага				Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		Тоо		Дүн		Тоо		Дүн	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Компанийн 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланд төрд шилжин ирсэн үеийн хугацааны 70,072.4 сая төгрөгийн зарцуулалт тайлагнасан 4 төлөвлөгөөний үзүүлэлтийг харгалзах хугацаагаар зэрэгцүүлээгүй, санхүүгийн тайлангийн тоо хэмжээ, өртөгтэй уялдуулаагүй, бодитой, ил тод тайлагнаагүй.	1	70,072.4			1	70,072.4												
2	Санхүүгийн тайлангийн эхний үлдэгдэлд шүүхийн шийдвэр гараагүй маргаантай урт хугацаат банкны зээлийн өглөг 41,916.8 сая, зээлийн хүүгийн өглөг 16,372.6 сая төгрөг, Хуучнаар Цемент шохой ХК-ийн удирдлага төрийн шийдвэрийг эс зөвшөөрч, хоёр тал хүлээлцээгүй	1	58,289.4			1	58,289.4												
			279,020.4				279,020.4												

/сая төгрөгөөр/

Үүнээс:



Цемент шохой ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн  
тайланд хийсэн аудитын тайлан

3	<p>Урт хугацаат хөрөнгө оруулалтын өглөг 275,738.8 сая, нэмж төлөгдсөн капитал 420.0 сая, эздийн өмчийн бусад хэсэг 2,861.6 сая төгрөг бүртгэлтэй байна.</p> <p>Тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй олон жилийн насжилттай авлага 42,964.1 сая, урьдчилж төлсөн тооцоо 758.7 сая, урьдчилж орсон орлого 171.8 сая, богино хугацаат өглөг 238.1 сая төгрөгийг тайлагнасан.</p>	44,132.7		44,132.7			
4	<p>Эргэлтийн хөрөнгөнд бүртгэлтэй 546.2 сая төгрөгийн өртөгтэй борлуулах зорилготой ККС-110 маркийн байшин кран байгууллагын эзэмшилд биетээр оршин байхгүй.</p> <p>Байгууллагын эзэмшлийн 27 газрыг санхүүгийн тайланд биет бус хөрөнгөөр үнэлж бүртгээгүй.</p> <p>Худалдан авалтын нээлттэй тендер шалгаруулсан 3 ажлын 908.8 сая, харьцуулалтын 3 ажлын 207.5 сая төгрөгийн худалдан авалтын гэрээнүүдийг аудитад ирүүлээгүй, мөн 16 ажлын 5,890.3 сая төгрөгийн гэрээг дүгнэсэн актгүй, худалдан авалтын гэрээний хэрэгжилтэд нийт 7,006.6 сая төгрөгийн зөрчилтэй. Тайлант онд бэлтгэн нийлүүлэгчдэд дээрх гэрээнүүдийн төлбөр 4,191.6 сая төгрөгийг зарцуулсан байна.</p>	546.2	1	546.2			
5	<p>Бариа материалын дансанд тайлант оны 4-12 сарын хугацаанд яаралтай ашиглагдахгүй 816.9 сая төгрөгийн бараа материалын худалдан авалт хийж, зарцуулагдаагүй их хэмжээний үлдэгдэл байна.</p>	816.9	1	816.9			
				7,006.6			

01  
 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА  
 СӨРӨГ  
 САНАЛ ДҮГНЭЛТ



Цемент шохой ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн  
тайланд хийсэн аудитын тайлан

	<p>-Гүйцэтгэх захирал, газар хэлтсийн дарга нар 7 хүн Дархан аймагт амьдрах байр түрээсэлж, 40.5 сая төгрөгийг байгууллагаас төлсөн. Улаанбаатар хотод компанийн төлөөлөгчийн газарт ТӨБЗГ-ын зөвшөөрөлгүй 206.4 м2 талбай бүхий байрыг 1м2-г 66,000 төгрөгөөр үнэлж түрээсэлсэн. Түрээсийн үнэ Засгийн газрын тогтоолоор баталсан үнэлгээнээс хэт өндөр 53.7 сая төгрөгийн илүү зардал гаргасан.</p> <p>-Компаниас эдийн засгийн форумд 66.2 сая, урлагийн наадам 10.2 сая, хөлбөмбөгийн талбай тохижуулахад 25.6 сая, ЗХЗ сагсан бөмбөгийн талбай тохижуулахад 22.3 сая, Сэлэнгэ аймгийн жудо бөхийн холбоо, 2-р цэцэрлэг, Орхон сумын ЗДТГ зэрэгт 26.1 сая, барилгачдын баярт 33.1 сая, хүлээн авалтын зардалд 14.4 сая төгрөгийг тус тус зарцуулж, нийт 1,109.0 сая төгрөгийн тэвчиж болох зардал гаргасан.</p>	292.3	292.3			
6	<p>Охин компани Хөтөл Энержи Дулаан ХХК-тай холбоотой нийт 2,310.8 сая төгрөгийн дараах зөрчил байна. Үүнд:</p> <p>-Дулаан, нүүрсний борлуулалтын авлага болон бусад авлагын үлдэгдэл 1,082.2 сая төгрөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй;</p> <p>-Бараа, ажил, үйлчилгээний худалдан авалтын 1,183.1 сая, зөвлөх үйлчилгээний 40.0 сая, нийт 1,223.1 сая төгрөгийн гэрээг дүгнэж, акт үйлдээгүй;</p> <p>-Борлуулалтын нягтлан бодогч, байцаагч, нарвуудын цалинг</p>	<p>1</p> <p>5.5</p>	<p>1,082.2</p> <p>1,223.1</p> <p>5.5</p>	1		



Цемент шохой ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн  
тайланд хийсэн аудитын тайлан

	<p>2022.07.01-ээс бууруулж, батлагдсан хэмжээнээс нийт 5.5 сая төгрөгийн ДУУУ цалин олгосон.</p>							
	<p>Нийт 58.0 сая төгрөгийн үргүй зардал гарсан байна. Үүнд: Гүйцэтгэх захирлын хувийн зардалд 6.4 сая төгрөг зарцуулсан.</p>	6.4	6.4					
	<p>Улаанбаатар оффисын үйл ажиллагаанд батлагдсан төлөвлөгөөнд тусгаагүй 27.0 сая төгрөгийг зарцуулсан бөгөөд анхан шатны баримтын бүрдэл ДУУУ /хоол, ундаа, кофены баримт хавсаргасан/.</p>	27.0	27					
7	<p>Хайрхан тахисан, бумбын баярт оролцсон 5.9 сая, баримтаар нотлогдоогүй ажилчдын хор саармагжуулах гэсэн гүйлгээний утгатай 11.0 сая төгрөгийг барилгын компанид шилжүүлсэн.</p>	16.9	16.9	1				
	<p>Томилолтын зардлыг Сангийн сайдын тушаалаар баталсан хэмжээнээс илүү, Улаанбаатар хотод ажлын байртай ажилтнуудад Хөтөлөөс-УБ гэсэн маршрутаар томилолтын зардалд 7.7 сая олгосон.</p>	7.7	7.7					
8	<p>Хөтөл Энержи Дулаан ХХК-ийн удирдлага тайлант онд томилолтын зардалд 2.6 сая, урлагийн бага наадамд 0.9 сая, улсын баяр наадамд 0.8 сая, барилгачдын баярт 1.8 сая төгрөгийг тус тус зарцуулж, татварын цахим И-баримтыг хавсаргаагүй, нийт 6.1 сая төгрөгийн зөрчил байна.</p>	6.1	6.1	1				
	Дүн	462,551.8	64.1	2	6	462,487.7		





Цемент шохой ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн  
тайланд хийсэн аудитын тайлан

6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил				Төлбөрийн акт				Үүнээс:			
		Тоо		Дүн		Тоо		Дүн		Тоо		Дүн	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
<b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>													
1	Цемент шохой ТӨХК нь тайлант оны 4-12 дугаар сард шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулбал зохих 168,166.9 сая төгрөгийн нийт 115 мэдээллээс 60 мэдээлэл хугацаанд нь байршуулж, 3 мэдээ хугацаа болоогүй, 72,050.2 сая төгрөгийн 50 мэдээллийг хугацаа хоцроож, дараа жилийн төсвийн төсөл, аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний 2 мэдээллийг огт мэдээлээгүй байна	1	72,050.2					1	72,050.2				
	<b>Дүн</b>	<b>1</b>	<b>72,050.2</b>					<b>1</b>	<b>72,050.2</b>				
<b>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой</b>													
	Худалдан авалтын төлөвлөгөөнд нээлттэй тендер шалгаруулахаар баталсан боловч 11,746.5 сая төгрөгийн 9 удаагийн худалдан авалтыг шууд гэрээ байгуулсан, төлөвлөгөөнд батлаагүй, дээд газрын шийдвэргүй 1 удаагийн 300.0 сая төгрөгийн худалдан авалт хийсэн, 262.3 сая төгрөгийн шууд худалдан авалт нь төлөвлөгөөнд байгаа ч оны эцэст тайлагнаагүй.		12,308.8						12,308.8				
	Өмгөөллийн зөвлөх үйлчилгээний худалдан авалтыг 13 салгаж шууд худалдан авалт хийсэн, ажил гүйцэтгэх гэрээгүүдийн үр дүн гараагүй үргэлжилж байгаа, 35.0 сая төгрөгийн авлагыг барагдуулахад зориулж 37.8 сая төгрөгийн гэрээ байгуулсан.		254.1						254.1				
1	Худалдан авалтын төлөвлөгөөнд батлуулаагүй, нээлттэй тендер шалгаруулах босго давсан 2,187.9 сая төгрөгийн 11 гэрээ, харьцуулалтын аргын босго 645.7 сая төгрөгийн 16 гэрээг шууд худалдан авалт хийсэн, гэрээг аудитад ирүүлээгүй.	1	2,833.6					1	2,833.6				
	Хөтөл Энержи Дулаан ХХК-ийн 1,885.7 сая төгрөгийн 3 худалдан авалт, Цемент шохой ТӨХК-ийн 3,867.7 сая төгрөгийн 2 худалдан авалтыг босго үнийг харгалзахгүйгээр шууд гэрээ байгуулахаар, Байгаль орчны дүйцүүлэн хамгаалалын 158.7 сая төгрөгийн гэрээний худалдан авалтыг харьцуулалтын аргаар хийхээр тус төлөвлөгөөнд батлуулсан.		5,912.1						5,912.1				
	<b>Дүн</b>	<b>1</b>	<b>21,308.6</b>					<b>1</b>	<b>21,308.6</b>				
	<b>Нийт дүн</b>	<b>2</b>	<b>93,358.8</b>					<b>2</b>	<b>93,358.8</b>				





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 03 дугаар сарын 24

№ 731 / АОНСОЛБ

Улаанбаатар хот

СНАГ-2023/02/КА-СТА-ТДА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Цемент шохой ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Компанийн 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайланд төрд шилжин ирсэн үеийн хугацааны 70,072,429,600.00 /далан тэрбум далан хоёр сая дөрвөн зуун хорин есөн мянга зургаан зуу/ төгрөгийн зарцуулалт тайлагнасан ч төлөвлөгөөний үзүүлэлтийг харгалзах хугацаагаар зэрэгцүүлээгүй, санхүүгийн тайлангийн тоо хэмжээ, өртөгтэй уялдуулаагүй, бодитой, ил тод тайлагнаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.8-д "Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн жилийн тайлан нь түүний зорилтын саналтай харьцуулан дүгнэж болох ижил үзүүлэлттэй байх бөгөөд шаардлагатай мэдээллийг агуулсан байна" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Компанийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний гүйцэтгэлийг ижил хугацаанд зэрэгцүүлэн үнэн зөв тайлагнах, албан шаардлагын биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гарахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цемент шохой ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Л.Наранбаатар, Төлөвлөлт, эдийн засгийн хэлтсийн дарга Х.Батсүрэн нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ДИ ЭЙ БИ ЖИ АУДИТ ХХК  
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ  
Я.САМБУУНЯМ

Н.ДЭЛГЭРМАА







ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 03 дугаар сарын 24 № 730/А0150118  
СНАГ-2023/08/НА-СТА-ТДА  
Зөрчил арилгах тухай

Улаанбаатар хот

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Цемент шохой ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Санхүүгийн тайлангийн эхний үлдэгдэлд шүүхийн шийдвэр гараагүй маргаантай урт хугацаат банкны зээлийн өглөг 41,916,835,529.58 /дөчин нэгэн тэрбум есөн зуун арван зургаан сая найман зуун гучин таван мянга таван зуун хорин есөн төгрөг тавин найман мөнгө/, зээлийн хүүгийн өглөг 16,372,618,946.34 /арван зургаан тэрбум гурван зуун далан хоёр сая зургаан зуун арван найман мянга есөн зуун дөчин зургаан төгрөг гучин дөрвөн мөнгө/, хуучнаар Цемент шохой ХК-ийн удирдлага төрийн шийдвэрийг эс зөвшөөрч, хоёр тал хүлээлцээгүй урт хугацаат хөрөнгө оруулалтын өглөг 275,738,820,300.00 /хоёр зуун далан таван тэрбум долоон зуун гучин найман сая найман зуун хорин мянга гурван зуу/ төгрөг, нэмж төлөгдсөн капитал 420,000,000.00 /дөрвөн зуун хорин сая/ төгрөг, эздийн өмчийн бусад хэсэг 2,861,655,327.46 /хоёр тэрбум найман зуу жаран нэгэн сая зургаан зуун тавин таван мянга гурван зуун хорин долоон төгрөг дөчин зургаан мөнгө/, нийт 337,309,930,103.38 /гурван зуун гучин долоон тэрбум гурван зуун есөн сая есөн зуун гучин мянга нэг зуун гурван төгрөг гучин найман мөнгө/ төгрөг бүртгэлтэй байна.

Мөн тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй олон жилийн насжилттай авлага 42,964,082,862.85 /дөчин хоёр тэрбум есөн зуун жаран дөрвөн сая наян хоёр мянга найман зуун жаран хоёр төгрөг наян таван мөнгө/, урьдчилж төлсөн тооцоо 758,687,008.47 /долоон зуун тавин найман сая зургаан зуун наян долоон мянга найман төгрөг дөчин долоон мөнгө/, урьдчилж орсон орлого 171,769,285.88 /нэг зуун далан нэгэн сая долоон зуун жаран есөн мянга хоёр зуун наян таван төгрөг наян найман мөнгө/, богино хугацаат өглөг 238,147,486.08 /хоёр зуун гучин найман сая нэг зуун дөчин долоон мянга дөрвөн зуун наян зургаан төгрөг найман мөнгө/, нийт 44,132,686,643.00 /дөчин дөрвөн тэрбум нэг зуун гучин хоёр сая зургаан зуун наян зургаан мянга зургаан зуун дөчин гурав/ төгрөгийг тайлагнасан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.3-д "Хувьчлал хүчингүй болсон тохиолдолд ТӨБЗ-ын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага уг зөрчлөөс үүссэн хохирлыг арилгах, эд хөрөнгийг хамгаалах арга хэмжээ авч, цаашид уг эд хөрөнгийг хэрхэх тухай шийдвэр гаргана", 71 дүгээр зүйлийн 71.8-д "өр авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2023\0324 SNAG-1.Docx

0001081518



Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн өмч хөрөнгийн маргааныг шийдвэрлэхэд анхаарах, өмгөөллийн зөвлөх үйлчилгээний ажлын үр дүнг тооцох, өмнөх үеийн авлагыг хууль хяналтын байгууллагад шилжүүлэн барагдуулах арга хэмжээ авч ажиллах, албан шаардлагын биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цемент шохой ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Л.Наранбаатар, Санхүү, бүртгэл тайлангийн хэлтсийн дарга Э.Гэлэгжамц нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ДИ ЭЙ БИ ЖИ АУДИТ ХХК  
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ  
Я.САМБУУНЯМ

Н.ДЭЛГЭРМАА





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 03 дугаар сарын 24 № 729/АЖСМГ  
СНАГ-2023/08/НА-СТА-ТДА  
Зөрчил арилгах тухай

Улаанбаатар хот

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Цемент шохой ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Компанийн эзэмшлийн 27 газрыг санхүүгийн тайланд биет бус хөрөнгөөр үнэлж бүртгээгүй, мөн эргэлтийн хөрөнгөнд бүртгэлтэй 546,192,946.00 /таван зуун дөчин зургаан сая нэг зуун ерэн хоёр мянга есөн зуун дөчин зургаа/ төгрөгийн өртөгтэй борлуулах зорилготой ККС-110 маркийн байшин кран компанийн эзэмшилд биетээр оршин байхгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д "хөлбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-д "Төрийн өмчит хуулийн этгээд эзэмшилдээ байгаа илүүдэл үндсэн эд хөрөнгө, түүнчлэн ашиглах хугацаа нь дууссан буюу эсхүл осол гэмтэлд өртсөний улмаас зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон бөгөөд засаж, сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тооцоогоор нотлогдсон эд хөрөнгийг худалдаж, шилжүүлж, акт тогтоон устгаж болно" гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Байгууллагын хөрөнгийг бүртгэлд бүрэн тусгах, хөрөнгийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулах арга хэмжээ авч ажиллах, албан шаардлагын биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цемент шохой ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Л.Наранбаатар, Санхүү, бүртгэл тайлангийн хэлтсийн дарга Э.Гэлэгжамц нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН,  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ДИ ЭЙ БИ ЖИ АУДИТ ХХК  
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ  
Я.САМБУУНЯМ

Н.ДЭЛГЭРМАА







ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 03 дугаар сарын 24 № 728 / А0150116  
СНАГ-2023/08/НА-СТА-ТДА  
Зөрчил арилгах тухай

Улаанбаатар хот

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Цемент шохой ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Худалдан авалтын нээлттэй тендер шалгаруулсан 3 ажлын 908,795,500.00 /есөн зуун найман сая долоон зуун ерэн таван мянга таван зуу/ төгрөг, харьцуулалтын 3 ажлын 207,493,506.00 /хоёр зуун долоон сая дөрвөн зуун ерэн гурван мянга таван зуун зургаа/ төгрөгийн худалдан авалтын гэрээнүүдийг аудитад ирүүлээгүй, мөн 16 ажлын 5,890,289,044.00 /таван тэрбум найман зуун ерэн сая хоёр зуун наян есөн мянга дөчин дөрөв/ төгрөгийн гэрээг дүгнэсэн актгүй, нийт 7,006,578,050.00 /долоон тэрбум зургаан сая таван зуун далан найман мянга тавь/ төгрөгийн зөрчил байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1-д "төрийн аудитын байгууллагын аудит хийхэд шаардагдах цаасан болон цахим хэлбэрийн мэдээлэл, баримт бичгээр хангах, уг мэдээлэл, баримт бичгийн үнэн зөв, бодитой, бүрэн байх шаардлагыг хариуцах", 16.1.4 "төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд шаардсан мэдээлэл, баримт бичгийг бүрэн ирүүлэх", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.2.10-д "гэрээг дүгнэж, бараа, ажил, үйлчилгээг хүлээж авсан баримт бичиг", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Худалдан авалтын гэрээний хэрэгжилтийг үнэлж, дүгнэн, баримт материалыг холбогдох хууль, журмын дагуу бүрдүүлэн архивлах, албан шаардлагын биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цемент шохой ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Л.Наранбаатар, Хуулийн хэлтсийн ахлах мэргэжилтэн П.Занабазар нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ДИ ЭЙ БИ ЖИ АУДИТ ХХК  
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ  
Я.САМБУУНЯМ  
Н.ДЭЛГЭРМАА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-264230

Z:\Alban Shaardlago\2023\0324 SNAG-1.Docx

0201081514





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 24

№ 727/АУСДМБ

Улаанбаатар хот

СНАГ/2022/08/КА-СТА-ТӨА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Цемент шохой ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Бараа материалын дансанд тайлант оны 4-12 сарын хугацаанд яаралтай ашиглахгүй 816,915,929.80 /найман зуун арван зургаан сая есөн зуун арван таван мянга есөн зуун хорин есөн төгрөг наян мөнгө/ төгрөгийн бараа материалын худалдан авалт хийж, зарцуулаагүй их хэмжээний үлдэгдэлтэй;
2. Гүйцэтгэх захирал, газар хэлтсийн дарга нар, нийт 7 хүн Дархан-Уул аймагт амьдрах байр түрээсэлж, 40,500,000.00 /дөчин сая таван зуун мянга/ төгрөгийг байгууллагаас төлсөн байна. Улаанбаатар хотод компанийн төлөөлөгчийн газарт ТӨБЗГ-ын зөвшөөрөлгүй 206.4 м2 талбай бүхий байрыг 1м.кв талбайг 66,000.00 төгрөгөөр үнэлж түрээсэлсэн. Түрээсийн үнэ Засгийн Газрын тогтоолоор баталсан үнэлгээнээс хэт өндөр 53,712,000.00 /тавин гурван сая долоон зуун арван хоёр мянга/ төгрөгийн илүү зардал гаргасан;
3. Компаниас эдийн засгийн форумд 66,182,950.00 /жаран зургаан сая нэг зуун наян хоёр мянга есөн зуун тавь/, урлагийн наадмын үйл ажиллагаанд зориулан 10,229,444.00 /арван сая хоёр зуун хорин есөн мянга дөрвөн зуун дөчин дөрөв/, хөл бөмбөгийн талбай тохижуулахад 25,685,000.00 /хорин таван сая зургаан зуун наян таван мянган/, 3х3 сагсан бөмбөгийн тэмцээн зохиоход 22,306,360.00 /хорин хоёр сая гурван зуун зургаан мянга гурван зуун жар/, Сэлэнгэ аймгийн жудо бөхийн холбоо, 2-р цэцэрлэг, Орхон сумын ЗДТГ зэрэгт 26,197,100.00 /хорин зургаан сая нэг зуун ерэн долоон мянга нэг зуу/, барилгачдын баяр зохион байгуулахад зориулан 33,110,000.00 /гучин гурван сая нэг зуун арван мянга/, хүлээн авалтын зардалд 14,400,000.00 /арван дөрвөн сая дөрвөн зуун мянга/ төгрөгийг тус тус зарцуулж нийт 1,109,238,783.80 /нэг тэрбум нэг зуун есөн сая хоёр зуун гучин найман мянга долоон зуун наян гурван төгрөг наян мөнгө/ төгрөгийн тэвчиж болох зардалд зарцуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.3-д "Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр хандивлах, бэлэглэх, барьцаалах, зээлдүүлэх, бусад өмчийн хуулийн этгээдэд хувь хөрөнгө болгон оруулахыг хориглоно", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.1-д "зардал бууруулахад чиглэсэн арга хэмжээг энгийн ойлгомжтой, тууштай, сахилга баттайгаар зохион байгуулах", 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгохыг хориглоно", 15.1.6-д "нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа материал бэлтгэх, нөөцлөхийг хориглоно" гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2023\0324 SNAG-1.Docx

0001081512



Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн өмчийн эд хөрөнгийг хэмнэх, үр ашигтай зарцуулах, холбогдох хууль, журмын дагуу эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авч ажиллах, албан шаардлагын биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цемент шохой ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Л.Наранбаатар, Санхүү, бүртгэл тайлангийн хэлтсийн дарга Э.Гэлэгжамц нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ДИ ЭЙ БИ ЖИ АУДИТ ХХК  
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ  
Я.САМБУУНЯМ

Н.ДЭЛГЭРМАА





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 03 дугаар сарын 24 № 726/АМСОМБ  
СНАГ-2023/08/КА-СТА-ТӨА  
Зөрчил арилгах тухай

Улаанбаатар хот

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Цемент шохой ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Цемент шохой ТӨХК-ийн охин компани Хөтөл Энержи Дулаан ХХК-тай холбоотой нийт 2,310,842,070.86 /хоёр тэрбум гурван зуун арван сая найман зуун дөчин хоёр мянга далан төгрөг наян зургаан мөнгө/ төгрөгийн зөрчил байна: Үүнд

1. Дулаан, нүүрсний борлуулалтын авлага болон бусад авлагын үлдэгдэл 1,082,230,412.86 /нэг тэрбум наян хоёр сая хоёр зуун гучин мянга дөрвөн зуун арван хоёр төгрөг наян зургаан мөнгө/ төгрөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй;
2. Бараа, ажил, зөвлөх үйлчилгээний худалдан авалтын 1,223,068,600.00 /нэг тэрбум хоёр зуун хорин гурван сая жаран найман мянга зургаан зуу/ төгрөгийн гэрээг дүгнэж, акт үйлдээгүй;
3. Борлуулалтын нягтлан бодогч, байцаагч, нярвуудын цалинг 2022 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс үндэслэлгүй бууруулж, батлагдсан цалингийн хэмжээнээс нийт 5,543,058.00 /таван сая таван зуун дөчин гурван мянга тавин найм/ төгрөгийн цалинг дутуу олгосон.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2-д "үйлдвэрийн газрын нэрийн өмнөөс эд хөрөнгийг энэ хууль, гэрээнд заасан эрх хэмжээний дотор захиран зарцуулах", 20.4-д "үйлдвэрийн газрын захиргааны бүтцийг тогтоож, албан тушаалтныг томилох, чөлөөлөх, эрх бүхий байгууллагаас тогтоосон цалингийн бүдүүвч сангийн хэмжээнд багтаан цалинг тогтоох", 71 дүгээр зүйлийн 71.8-д "өр авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцсон байх", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.2.10 "гэрээг дүгнэж, бараа, ажил, үйлчилгээг хүлээж авсан баримт бичгийг тендерийн хавтаст хэрэгт бүрдүүлнэ", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2023\0324\SNAG-1.Docx

0001081510



“Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д заасныг үндэслэн  
**ШААРДАХ нь:**

1. Авлага, өглөгийн тооцооны үлдэгдлийг харилцагч байгууллагатай актаар баталгаажуулах, худалдан авалтын гэрээний хэрэгжилтийг үнэлж, дүгнэн, баримт материалыг холбогдох хууль, журмын дагуу бүрдүүлэн архивлаж байх, албан шаардлагын биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хөтөл Энержи Дулаан ХХК-ийн гүйцэтгэх захирал Х.Мөнхбаяр, Ерөнхий санхүүч Ж.Саранбилэг нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ДИ ЭЙ БИ ЖИ АУДИТ ХХК  
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ  
Я.САМБУУНЯМ

Н.ДЭЛГЭРМАА







ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 24

№ 725 / АМСОМБ

Улаанбаатар хот

СКАГ-2022/08/КА-СТТ-ТДА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Цемент шохой ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд хийсэн худалдан авалтын үйл ажиллагааг батлагдсан төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлсэн эсэхийг тендерийн баримт материалтай тулган шалгахад нийт 21,308,692,115.80 /хорин нэгэн тэрбум гурван зуун найман сая зургаан зуун ерэн хоёр мянга нэг зуун арван таван төгрөг аян мөнгө/ төгрөгийн зөрчил байна. Үүнд:

1. Худалдан авалтын төлөвлөгөөнд нээлттэй тендер шалгаруулахаар баталсан боловч 11,746,529,700.00 /арван нэгэн тэрбум долоон зуун дөчин зургаан сая таван зуун хорин есөн мянга долоон зуу/ төгрөгийн 9 удаагийн худалдан авалтыг шууд гэрээ байгуулсан, төлөвлөгөөнд батлуулаагүй, дээд газрын шийдвэргүй 300,000,000.00 /гурван зуун сая/ төгрөгийн 1 удаагийн худалдан авалт хийсэн, 262,315,200.00 /хоёр зуун жаран хоёр сая гурван зуун арван таван мянга хоёр зуу/ төгрөгийн шууд худалдан авалт нь төлөвлөгөөнд байгаа боловч оны эцэст тайлагнаагүй;
2. Өмгөөллийн зөвлөх үйлчилгээний нийт 254,100,000.00 /хоёр зуун тавин дөрвөн сая нэг зуун мянга/ төгрөгийн худалдан авалтыг 13 салгаж шууд худалдан авалт хийсэн, ажил гүйцэтгэх гэрээнүүдийн үр дүн гараагүй үргэлжилж байгаа, үүний дотор 35,000,000.00 /гучин таван сая/ төгрөгийн авлагыг барагдуулахад зориулж 37,800,000.00 /гучин долоон сая найман зуун мянга/ төгрөгийн гэрээ байгуулсан;
3. Худалдан авалтын төлөвлөгөөнд батлуулаагүй, нээлттэй тендер шалгаруулах босго давсан 2,187,822,155.00 /хоёр тэрбум нэг зуун наян долоон сая найман зуун хорин хоёр мянга нэг зуун тавин таван/ төгрөгийн 11 гэрээ, харьцуулалтын аргын босго давсан 645,715,054.80 /зургаан зуун дөчин таван сая долоон зуун арван таван мянга тавин таван/ төгрөгийн 16 гэрээг шууд худалдан авалт хийсэн, гэрээг аудитад ирүүлээгүй;
4. Хөтөл Энержи Дулаан ХХК-ийн 1,885,730,600.00 /нэг тэрбум найман зуун наян таван сая долоон зуун гучин мянга зургаан зуу/ төгрөгийн 3 худалдан авалт, Цемент шохой ТӨХК-ийн 3,867,723,800.00 /гурван тэрбум найман зуун жаран долоон сая долоон зуун хорин гурван мянга найман зуу/ төгрөгийн 2 худалдан авалтыг босго үнийг харгалзахгүйгээр шууд гэрээ байгуулахаар, Байгаль орчны дүйцүүлэн хамгааллын 158,755,606.00 /нэг зуун тавин найман сая долоон зуун тавин таван мянга зургаан зуун зургаа/ төгрөгийн худалдан авалтыг харьцуулалтын аргаар хийхээр тус тус төлөвлөгөөнд батлуулсан.



Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1-д "төрийн аудитын байгууллагын аудит хийхэд шаардагдах цаасан болон цахим хэлбэрийн мэдээлэл, баримт бичгээр хангах, уг мэдээлэл, баримт бичгийн үнэн зөв, бодитой, бүрэн байх шаардлагыг хариуцах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2-д "үйлдвэрийн газрын нэрийн өмнөөс эд хөрөнгийг энэ хууль, гэрээнд заасан эрх хэмжээний дотор захиран зарцуулах", 20.7-д "тогтоосон журмын дагуу анхан шатны бүртгэлийг хөтөлж нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцэл, статистикийн мэдээ гаргах ажлыг зохион байгуулж, тэдгээрийн үнэн зөвийг хариуцах", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйл "Худалдан авах ажиллагааны журмыг сонгох", МУЗГ-ын 2021 оны 124-р тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны журмыг сонгоход баримтлах босго үнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулах, тендерийн анхан шатны баримт материалыг бүрэн бүрдүүлэн архивлах, албан шаардлагын биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цемент шохой ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Л.Наранбаатар, Худалдан авах ажиллагааны хэлтсийн дарга Д.Амгаланбаяр нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ДИ ЭЙ БИ ЖИ АУДИТ ХХК  
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ  
Я.САМБУУНЯМ

Н.ДЭЛГЭРМАА







ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 03 дугаар сарын 24 № 424 / А0150116  
СНАГ-2023/08 / КА-СТ-ТД  
Зөрчил арилгах тухай

Улаанбаатар хот

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Цемент шохой ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Цемент шохой ТӨХК нь тайлант оны 4-12 дугаар сард шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод байршуулбал зохих 168,166,900,000.00 /нэг зуун жаран найман тэрбум нэг зуун жаран зургаан сая есөн зуун мянга/ төгрөгийн нийт 115 мэдээллээс 72,050,146,419.85 /далан хоёр тэрбум тавин сая нэг зуун дөчин зургаан мянга дөрвөн зуун арван есөн төгрөг наян таван мөнгө/ төгрөгийн 50 мэдээллийг хугацаа хоцроож, дараа жилийн төсвийн төсөл, аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний 2 мэдээллийг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3 "тогтоосон хугацаанд тогтмол шуурхай оруулж байх", Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам"-ын холбогдох заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж, мэдээллийг тогтоосон хугацаанд тогтмол мэдээлэх, албан шаардлагын биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цемент шохой ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Л.Наранбаатар, Санхүү, бүртгэл тайлангийн хэлтсийн дарга Э.Гэлэгжамц нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ДИ ЭЙ БИ ЖИ АУДИТ ХХК  
ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ  
Я.САМБУУНЯМ  
Н.ДЭЛГЭРМАА







ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2023 оны 03 дугаар сарын 24 № 185/А.0150116

Улаанбаатар хот

СНАГ-2023/08/НА-УТА-ТӨА

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Цемент шохой ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Гүйцэтгэх захирлын хувийн зардалд 6,406,750.00 /зургаан сая дөрвөн зуун зургаан мянга долоон зуун тавь/ төгрөг, Улаанбаатар оффисын үйл ажиллагаанд батлагдсан төлөвлөгөөнд тусгаагүй 26,952,000.00 /хорин зургаан сая есөн зуун тавин хоёр мянга/ төгрөгийг тус тус зарцуулсан бөгөөд анхан шатны баримтын бүрдэл дутуу /хоол, ундаа, кофены баримт хавсаргасан/, хайрхан тахисан, бумбын баярт оролцсон 5,923,150.00 /таван сая есөн зуун хорин гурван мянга нэг зуун тавь/, томилолтын зардлыг Сангийн сайдын тушаалаар баталсан хэмжээнээс илүү, Улаанбаатар хотод ажлын байртай ажилтнуудад Хөтөлөөс-УБ гэсэн маршрутаар томилолтын зардалд 7,718,100.00 /долоон сая долоон зуун арван найман мянга нэг зуу/ төгрөг олгосон, баримтаар нотлогдоогүй ажилчдын хор саармагжуулах гэсэн гүйлгээний утгатай 11,000,000.00 /арван нэгэн сая/ төгрөгийг барилгын компанид шилжүүлсэн зэрэг нийт 58,000,000.00 /тавин найман сая/ төгрөгийн үргүй зардал гарсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгохыг хориглоно", 15.1.7-д "байгууллагын төсвөөр согтууруулах ундаа худалдан авах" гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж, үргүй зарцуулсан 58,000,000.00 /тавин найман сая/ төгрөгийг буруу шийдвэр гаргасан холбогдох албан тушаалтнаар төлүүлж, Төрийн сан дахь Үндэсний аудитын газрын Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Цемент шохой ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Л.Наранбаатар, Санхүү, бүртгэл тайлангийн хэлтсийн дарга Э.Гэлэгжамц нарт даалгав.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ДИ ЭЙ БИ ЖИ АУДИТ ХХК  
ЗАХИРАЛ

АКТ ТОГТООСОН:

Ц.НАРАНЧИМЭГ  
Я.САМБУУНЯМ

Н.ДЭЛГЭРМАА

ATA9693 9006109  
9023030583

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-264230

Z:\Akt\2023\0324 SNAG-1.Docx

0001390218





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2023 оны 03 дугаар сарын 24

№ 184/A0150116

Улаанбаатар хот

СНАГ-2023/08/НА-УТА-ТӨА

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Цемент шохой ТӨХК-ийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Цемент шохой ТӨХК-ийн охин компани болох Хөтөл Энержи Дулаан ХХК-ийн удирдлага тайлант онд томилолтын зардалд 2,577,500.00 /хоёр сая таван зуун далан долоон мянга таван зуу/ төгрөг илүү зарцуулсан, урлагийн бага наадмын үйл ажиллагаанд 900,000.00 /есөн зуун мянга/, улсын баяр наадам зохион байгуулахад 789,000.00 /долоон зуун наян есөн мянга/, барилгачдын баяр зохион байгуулахад 1,839,400.00 /нэг сая найман зуун гучин есөн мянга дөрвөн зуу/, нийт 6,105,900.00 /зургаан сая нэг зуун таван мянга есөн зуу/ төгрөгийг тус тус үргүй зарцуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.3-д "Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр хандивлах, бэлэглэх, барьцаалах, зээлдүүлэх, бусад өмчийн хуулийн этгээдэд хувь хөрөнгө болгон оруулахыг хориглоно", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгохыг хориглоно" гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д заасныг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж, үргүй зарцуулсан 6,105,900.00 /зургаан сая нэг зуун таван мянга есөн зуун/ төгрөгийг буруутай албан тушаалтнаар төлүүлж, Төрийн сан дахь Үндэсний аудитын газрын Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Цемент шохой ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Л.Наранбаатар, Санхүү, бүртгэл тайлангийн хэлтсийн дарга Э.Гэлэгжамц нарт даалгав.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ДИ ЭЙ БИ ЖИ АУДИТ ХХК  
ЗАХИРАЛ



Ц.НАРАНЧИМЭГ  
Я.САМБУУНЯМ

Н.ДЭЛГЭРМАА